

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 43.020

Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага	MNS 5122 : 2013
Public taxi service General requirements	MNS 5122 : 2008-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 09 дүгээр сарын 25- ны өдрийн 41 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Энэхүү стандарт нь таксийн үйлчилгээг зохион байгуулах, нийтлэг шаардлагыг тогтоох, тавих, ажил үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2. Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандартыг таксийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, таксийн жолооч, хэрэглэгч байгууллага, иргэн дагаж мөрдөнө.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартыг боловсруулахад дараах норматив баримт бичгийг ашигласан бөгөөд дахин хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг иш татаж хэрэглэнэ. Үүнд:

- MNS ISO 3833:2010, Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт
- MNS 4598 : 2011, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага,
- MNS 4601:2011, Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт
- MNS 5012 : 2011, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага,
- MNS 5342 : 2007, Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага.
- БНБД 31-03-03, Олон нийт иргэний барилга

4. Нэр томьёо ба тодорхойлолт

4.1. Энэхүү стандартад хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

4.1.1.

Такси

Зорчигч болон тээш, гар тээш тээвэрлэхэд зориулагдсан, төлбөртэй явсан замын урт болон үйлчилгээний үнийг тооцох зориулалтын төхөөрөмжөөр тоноглогдсон, тусгай таних тэмдэг бүхий суудлын автомашин;

4.1.2.

Таксийн үйлчилгээ

MNS 5122 : 2013

Таксийн зориулалтын зогсоолоос эсвэл дуудлагаар энэхүү стандартын 7-д заасан үйлчилгээг зорчигчдод үзүүлэх тээвэрлэлт;

4.1.3.

Зорчигч

Таксигаар зорчиж байгаа зорчигч;

4.1.4.

Таксометр

Үйлчлүүлэгчийн явсан зай, хугацаа, үйлчилгээний төлбөрийг тооцоолж дүнг хэвлэх төхөөрөмж;

4.1.5.

Тээвэрлэгч

Таксийн ажил, үйлчилгээ эрхэлж буй этгээд;

4.1.6.

Таксийн жолооч

Энэхүү стандартын 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан, таксийн үйлчилгээ үзүүлж буй жолооч;

4.1.7.

Дуудлагын таксийн үйлчилгээ

Урьдчилсан захиалга өгсөн таксийн үйлчилгээ;

4.1.8.

Таксийн зогсоол

Такси болон үйлчлүүлэгч зогсоход зориулж тусгайлан тоногдсон зориулалтын барилга байгууламж, талбай;

4.1.9¹

Хөдөлгөөнт төхөөрөмжинд зориулсан такси үйлчилгээний програм хангамж

Такси үйлчилгээний дуудлага хүлээн авч, нийт явсан замыг байршилаар нь тодорхойлох технологи ашиглан тооцооллож, дэлгэцэнд харуулах үйлдлийг гүйцэтгэдэг програм хангамж

5. Тээвэрлэгчид тавих ерөнхий шаардлага

5.1. Тээвэрлэгч нь дараах шаардлагыг хангасан байна.

5.1.1. Таксийн үйлчилгээг гүйцэтгэх жолооч, мэргэжлийн боловсон хүчний чадавхитай байх.

5.1.2. Холбогдох хууль тогтоомж, стандартаар тогтоосон шаардлагыг хангасан, таксийн зориулалтын суудлын автомашинтай байх.

5.1.3. Таксийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын техникийн асуудлыг шууд эрхлэн удирддаг албан тушаалтан нь авто тээврийн мэргэжлийн, мэргэшсэн инженерийн сургалтанд хамрагдаж үнэмлэх, гэрчилгээ авсан байна.

¹ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоол

- 5.1.4.** Тээвэрлэгч нь таксийн үйлчилгээг гүйцэтгэх санхүү, эдийн засгийн чадавхитай байх.
- 5.2.** Тээвэрлэгч нь аймаг, нийслэлийн автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай тээвэрлэлтийн гэрээ байгуулсан байх.
- 5.3.** Таксийн үйлчилгээг гэрээнд заасан нутаг дэвсгэрийн хүрээнд гүйцэтгэх.
- 5.4.** Таксийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах, жолооч, зорчигчдын аюулгүй байдлыг хангах, хяналт тавих зорилгоор холбоо, мэдээллийн хэрэгсэл болон байрлал тогтоох, бүртгэл хяналтын төхөөрөмжтэй байна.
- 5.5.** Тээвэрлэгч нь нийслэлд 30, хөдөө орон нутагт 15-аас доошгүй такситай, үүний 60 -аас доошгүй хувь нь өөрийн өмчлөлийнх байна.
- 5.6.** Тээвэрлэгчийн нийт таксийн 10-аас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэд тээвэрлэхэд зориулагдсан хамгаалалтын бэхэлгээ, сандалтай байна.
- 5.7.** Тээвэрлэгч нь жолооч нарыг нэг загварын дүрэмт хувцасаар хангасан байна.
- 5.8.** Өөрийн өмчийн эсвэл түрээсийн үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтын барилга байгууламжтай байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 5.8.1.** Техникийн оношлогоо, засвар үйлчилгээний зориулалтын байртай байх.
- 5.8.2.** Дулаан гарааштай (нийт таксийн 60 %-иас дээш хувийг хадгалах багтаамж бүхий) байх.
- 5.8.3.** Автомашин угаалгын байртай байх.
- 5.8.4.** Тээвэрлэгч нь 10-аас 15 такси тутамд засвар үйлчилгээний 1-ээс доошгүй суваг болон өргүүртэй байх.
- 5.8.5** Техникийн оношлогоо, үйлчилгээ, засварын байр, дулаан гараашийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмж нь БНБД 31-03-03 барилгын норм дүрэмд заасан шаардлагыг хангасан байна.
- 5.8.6**² Тээвэрлэгч нь такси үйлчилгээнд явж буй жолоочийг тогтсон тарифын дагуу үйлчилж байгаа эсэхийг шалгах, хөдөлгөөнт төхөөрөмжинд зориулсан такси үйлчилгээний програм хангамж ашиглан явж байгаа бол тухайн програм хангамжид үйлчилгээний тарифыг жолооч өөрчлөх боломжгүй байх шаардлагыг тавьж ажиллана.

² Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоол

6. Таксинд тавих шаардлага

6.1. Такси нь “Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598 : 2011 стандарт болон дараах шаардлагыг хангасан, зүүн гар талдаа жолооны хүрдтэй суудлын автомашин байна. Үүнд:

6.2 Таксинд “**TAXI**” гэсэн бичиглэл бүхий гэрлэн хаяг /симфор/, таних тэмдэг, тээвэрлэгч байгууллагын лого, харилцах утасны болон автомашины гараашийн дугаарыг тавьж, таксометрээр тоногдсон байна.

6.3 Такси нь нэгэн жигд өнгөтэй байна.

6.4 Зорчигчийн суудал бүр хамгаалалтын бүстэй байна.

6.5 Таксийн таних тэмдэг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.5.1 Таних тэмдэгийн хэмжээ нь уртын дагуу 600 мм х 60 мм-ээс, доторх шоонууд нь 30 мм х 30 мм-ээс багагүй хэмжээтэй хар, цагаан эсвэл ногоон өнгө алгасан хосолсон байна. /А.хавсралтыг үзэх/

6.5.2 Тээвэрлэгчийн лого нь таксийн урд талын 2 хаалган дээр 350 мм х 200 мм-ийн хэмжээс бүхий хүрээнд багтсан байна.

6.5.3 Таксийн гараашийн дугаар нь арын салхины шилний 2 талын баганад 140 мм х 80 мм хэмжээтэй байна. /А.хавсралтыг үзэх/

6.5.4 Гараашийн болон харилцах утасны дугаарын нэг тооны хэмжээ нь 45 мм х 30 мм байна./А.хавсралтыг үзэх/

6.6 Таксийн бүхээгт байгууллагын нэр, жолоочийн өнгөт зураг, овог нэр, автомашины улсын ба гараашийн дугаарыг А6 хэмжээнээс багагүй хүрээнд бичиж зорчигчдод харагдах газар хөдөлгөөнгүйгээр байрлуулна.

6.7 Таксийн үйлчилгээний үнийг А5 хэмжээтэй хүрээнд Arial үсгийн фондоор 120 хэмжээгээр бичиж таксийн баруун талын арын хаалганы гадна байрлуулна.

6.8 Таксийн үйлчилгээнд үйлдвэрлэснээс хойш 12-аас дээш жил болсон автомашин ашиглахыг хориглоно.

6.9 Таксийн салхины шилэнд гэрлийн нэвтрүүлэх чадварыг бууруулах наалт наахыг хориглоно.

6.10 Такси үйлчилгээнд нөөц дугуй тавьж зорчигчдод үйлчлэхийг хориглоно.

7 Таксийн үйлчилгээнд тавих шаардлага

7.1 Таксийн үйлчилгээний захиалгыг дараах хэлбэрээр авна. Үүнд:

7.1.1 таксийн зогсоолоос,

7.1.2³ харилцах утсаар тээвэрлэгчийн хүлээн авсан дуудлагаар, эсвэл хөдөлгөөнт төхөөрөмжинд зориулсан такси үйлчилгээний программ хангамжаар дамжуулан хүлээн авсан дуудлагаар.

7.2 Такси дуудлагын үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллага тогтооно.

7.3 Тээвэрлэгч нь таксийг үйлчилгээнд гарахын өмнө техникийн бэлэн байдлыг шалгаж, замын хуудсанд тэмдэглэл хийж баталгаажуулна.

7.4 Тээвэрлэгч нь дараах баримт бичигтэй жолоочийг үйлчилгээнд гаргана. Үүнд:

7.4.1 Тээврийн хэрэгслийн гэрчилгээ,

7.4.2 Жолоочийн эрхийн үнэмлэх,

7.4.3 Мэргэшсэн жолоочийн үнэмлэх,

7.4.4 Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээ,

7.4.5 Заавал даатгах даатгалын баримт бичиг эсвэл гэрээ,

7.4.6 ~~Замын хуудас.~~

7.5 Таксины жолоочийн ажил, амралтын дэглэмийг Монгол Улсын хөдөлмөрийн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

7.6 Жолооч нарыг үйлчилгээнд гарахын өмнө өдөр бүр эрүүл мэндийн үзлэгт /цусны даралт, согтуу болон мансуурсан эсэх/ оруулсан байх.

7.7 Жолооч нь зорчигчийг захиалгын дагуу хамгийн ойр, осолгүй замаар хүргэнэ. Явах чиглэлээ зорчигчтой тохиролцон өөрчилж болно.

7.8 Такси нь захиалгагүй, зорчигчгүй явах үедээ урьд салхины шилний баруун дээд хэсэгт бүхээгний дотор талд ногоон гэрэл асааж явна.

7.9 Таксийн техникийн үйлчилгээ, засварын ажилд “Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт” MNS 4601:2011 стандартын шаардлагыг хангаж ажиллана.

7.10⁴ Таксометрийг хэмжил зүйн байгууллагаар жилд нэг удаа шалгуулж, баталгаажуулсан байна. Хөдөлгөөнт төхөөрөмжинд зориулсан такси үйлчилгээний програм хангамжийн хувьд жилд нэг удаа такси үйлчилгээний тарифын өөрчлөлт удирдлагын хэсэг болон байршил хэмжилтийн шалгалтыг хийдэг байна.

7.11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн, нялх хүүхэдтэй эхчүүд, бага насны хүүхэд, өндөр настан зэрэг хүмүүсийг таксинд суулгах, буулгахад жолооч анхаарал тавьж заавал тусална. Мөн такси замд саатсан тохиолдолд зорчигчийг өөр таксинд суулгаж өгнө.

³ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоол

⁴ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоол

7.12 Таксины жолооч нь тухайн нутаг дэвсгэрийн газрын зураг, томоохон албан газар, зочид буудал болон цагдаа, гал, эмнэлгийн түргэн тусламжийн байгууллагын хаяг, харилцах утасны лавлахтай байна.

7.13 Жолооч нь үйлчилгээ эхэлсэн, дууссан цаг болон үйлчилгээний явцын мэдээллийг цаг тухай бүр тээвэрлэгчид мэдэгдэнэ.

7.14 Тээвэрлэгч нь үйлчлүүлэгчээс авсан захиалгыг 5 минутад багтаан жолоочид дамжуулж, захиалга өгсөн үйлчлүүлэгчид таксийн дугаар, очих хугацааг мэдэгдэнэ.

7.15 Захиалгыг хүлээн авах үед үйлчилгээнд сул такси байхгүй тохиолдолд үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх боломжгүйг мэдэгдэн, захиалгыг хэрхэн шийдвэрлэх талаар тохиролцоно.

7.16 Таксийн үйлчилгээнд тавих шаардлагын түвшинг үндэслэн үйлчилгээний тариф ялгаатай байж болно.

7.17 Таксины дотор, гадна тал, шал, сандал, түшлэгийн бүрээс, бариул зэрэг нь тоос, тосгүй цэвэр байна.

7.18 Жолооч нь үйлчилгээний үед тамхи татах, утсаар ярихыг хориглоно.

7.19⁵ Такси нь спидометргүй, таксометргүй болон тэдгээр нь лац ломбогүй, баталгаажуагүй, эвдэрч гэмтсэн бол үйлчилгээнд гаргахыг хориглоно. Хөдөлгөөнт төхөөрөмжинд зориулсан такси үйлчилгээний програм хангамжийн суурилах төхөөрөмж нь ажиллагааны бүрэн бүтэн байдлыг хангаагүй бол үйлчилгээнд гаргахыг хориглоно.

8 Таксийн зогсоолд тавих шаардлага

8.1 Таксийн зогсоол нь “Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага” MNS 5342 : 2007 стандартын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд ашиглалтын байдлаар нь байнгын ба түр гэж ангилна.

8.2 Байнгын зогсоол нь худалдаа үйлчилгээний цэг, салбарууд төвлөрсөн, зорчигч урсгал, хүн амын бөөгнөрөл ихтэй газруудад зогсоолын тэмдэг, гэрэлтүүлэг, сандал, сүүдрэвчээр тоноглогдсон цардмал талбай байна.

8.3 Түр зогсоол нь хүн амын хөдөлгөөний урсгал багатай, албан байгууллага, худалдаа үйлчилгээний газруудын ойролцоох гол зам, гудамж талбайд зогсоолын тэмдэг, гэрэлтүүлгээр тоноглогдсон зогсоол байна.

8.11 Таксийн байнгын болон түр зогсоолыг тухайн орон нутгийн холбогдох байгууллагын зөвшөөрлөөр байгуулах ба хүн амын таксигаар зорчих эрэлт хэрэгцээнд нийцсэн, хөдөлгөөний аюулгүй байдлын болон автозамын ашиглалтын шаардлагыг бүрэн хангасан байна.

⁵ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоол

9 Таксийн жолоочид тавих шаардлага

9.1 Жолооч нь тухайн ангилалын жолоодох эрхийн үнэмлэхтэй, 21-ээс дээш настай, 2-оос дээш жил жолоочоор ажилласан байна.

9.2 Нийтийн тээврийн мэргэшсэн жолоочийн сургалтанд хамрагдаж үнэмлэх авсан байна.

9.3 Жолооч нь таксийн үйлчилгээ үзүүлэх нутаг дэвсгэр, гудамж замын сүлжээг сайтар мэддэг, харилцааны өндөр соёлтой хүн байна.

10 Зорчигчдод тавих шаардлага

10.1⁶ Таксигаар үйлчлүүлсэн үйлчилгээний үнийг таксометрийн заалтаар, хөдөлгөөнт төхөөрөмжинд зориулсан такси үйлчилгээний программ хангамж ашигладаг бол хөдөлгөөнт төхөөрөмжийн дэлгэц дээрх үнээр төлнө.

10.2 Таксигаар үйлчлүүлэхдээ ачаа тээшийг зориулалтын сав, баглаа боодолтой авч явна.

10.3 Таксид хамгаалалтын хэрэгсэлгүй нохой амьтан тээх, тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис, эвгүй үнэртэй зүйл, овор хэмжээ ихтэй ачаа тээшийг тээвэрлэхийг хориглоно.

10.4 Таксигаар биеэ авч явах чадваргүй зорчигч асран хамгаалагчтайгаар үйлчлүүлнэ.

10.5 Таксийн суудал, суудлын бүрээс, хаалга бусад тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээхгүй зориулалтын дагуу ашиглана.

10.6 Зорчигч нь таксид архи уух, тамхи татахыг хориглоно.

ТӨГСӨВ.

⁶ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны 24 дүгээр тогтоол

Стандарт, хэмжил зүйн газар.

Стандартын Үзлэг-2018